



**ХЭНТИЙ АЙМГИЙН  
ХЭРЛЭН СУМЫН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ**

2025 оны 06 сарын 02 өдөр

Дугаар 1/162

Хэрлэн сум

**Байгууллагын дэргэдэх Баримт нягтлан  
шалгах комисс байгуулах тухай**

Монгол Улсын Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсэг, Архив, албан хэрэг хөтлөлтийн тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1 дэх хэсэг, 24 дүгээр зүйлийн 24.1.7 дахь заалт, Хууль зүй, дотоод хэргийн сайдын 2021 оны 10 дугаар сарын 06-ны өдрийн А/222 дугаар тушаалаар баталсан "Байгууллагын архивын үйл ажиллагааны нийтлэг журам"-ын 2.3.7, 2.8 дахь заалтуудыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Хэрлэн сумын Засаг даргын Тамгын газрын дэргэдэх Баримт нягтлан шалгах комиссыг дараах бүрэлдэхүүнтэйгээр байгуулсугай. Үүнд:

|                       |                                                        |
|-----------------------|--------------------------------------------------------|
| Комиссын дарга:       | Засаг даргын Тамгын газрын дарга                       |
| Нарийн бичгийн дарга: | Архив, бичиг хэргийн эрхлэгч                           |
| Гишүүд:               | Төрийн сангийн мэргэжилтэн                             |
|                       | Хөдөө аж ахуйн мэргэжилтэн                             |
|                       | Дотоод ажил, хяналт, хүний нөөц хариуцсан мэргэжилтэн  |
|                       | Дотоод сүлжээ сургалт, сурталчилгаа хариуцсан ажилтан  |
|                       | Барилга, дэд бүтэц, хөрөнгө оруулалт хариуцсан ажилтан |

2.Байгууллагын хөтлөх хэргийн нэрийн жагсаалт боловсруулах, хэрэг бүрдүүлэх, хөтлөгдөж дууссан хэргүүдийг архивт шилжүүлэхэд бэлтгэх явцад хяналт тавих, байнгын хадгалалтад баримт сонгох болон холбогдох төрийн архивт нөхөн бүрдүүлэлт хийх үйл ажиллагааг зохион байгуулах зэрэг чиг үүргүүдийг чанартай хэрэгжүүлж ажиллахыг комисст даалгасугай.

3.Комиссын үйл ажиллагааг цаг тухайд нь баримтжуулж, холбогдох дүрэм журмын дагуу зохион байгуулсан ажлын тайланг цаг тухай бүрт нь тайлагнаж байхыг комиссын даргад үүрэг болгосугай.

4.Энэхүү захирамж гарсантай холбогдуулан 2019 оны 03 дугаар сарын 05-ны өдрийн А/46 дугаар захирамжийг хүчингүй болсонд тооцсугай

ДАРГА



Д.ЭРДЭНЭБААТАР

Албан тоот 2024\Zahiraml\Захирамж 2024.doc

231110374